



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал,
амралтын газрын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сэлбэ Оюу ХХК-ийн “Сэлбэ плаза” зочид буудлын 17/203, Зориг Халиун ХХК-ийн “Бэлх” зочид буудлын 17/069, Энх Нинж Цэнд ХХК-ийн “Буудай” дэн буудлын 17/074, Алтайн Ундрах шанд ХХК-ийн

1150500276

“Тайга” дэн буудлын 17/188, Алкес ХХК-ийн Жүли дэн буудлын 17/153, Хишиг Арвин ХХК-ны Хишиг Монгол амралтын газрын 17/220 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг тогтоол шийдвэр, тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 19 өдрийн А/83 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-2926 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сэлбэ Оюу ХХК	5701694	Сэлбэ плаза	БГД-ийн 5-р хороо 10 хороолол, Энхтайваны өргөн чөлөө 89/01 тоот
2	Дун өргөө ХХК	5214696	Өргөө	ЧД-ийн 1-р хороо Жуулчны гудамж М-1000 байр
3	Биг авто молл партс ХХК	5546826	Нисдэг машин	ЧД-ийн 5-р хороо Тасганы овоо 15/150 ИХ тойруу 23
4	Долоон бурхан буган халиун ХХК	6280323	Буган халиун	ХУД-ийн 11-р хороо 4 хэсэг дайчдын хөшөө 1-66 тоот

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 19-өдрийн А/ВЗ дугаар
тушаалын хоёрдугаар хэвсрэлт

5284025 СБТ 48936 1116263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Энх Нинж Цэнд ХХК	6149065	Буудай	БЗД-ийн 7-р хороо Доржийн гудамж 3-21 тоот
2	Их цагаан даваа ХХК	5181819	Сарнай	БЗД-ийн 1-р хороо 17А байр
3	Алкес ХХК	2569809	Жүли	БЗД-ийн 6-р хороо Олзвойн гудамж
4	Алтайн ундрах шанд ХХК	6261191	Тайга	СБД-ийн 9-р хороо Их тойруу 46-р байр 63 тоот
5	Зориг Халиун ХХК	5037298	Бэлх	СБД-ийн 18 хороо 35-51 тоот
6	ДСЭМ сервис ХХК	5350298	Дэн буудал	ЧД-ийн 6 хороо Их тойруу 11-01 тоот

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 19 өдрийн А/83 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284025 СБТ-8936 1116263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хишиг-Арвин ХХК	2692309	Хишиг- Монгол	ХУД-ийн 14-р хороо Түргэний ам